



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/367

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Ус, хөрс бохирдохоос сэргийлж авто зам дагуу болон жуулчид ихээр цуглардаг үзэсгэлэнт газар, нуурын эрэгт стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламж байгуулах (Тэшиг сум Харгал нуур 10ш) Багц №1 Тэшиг сумын Харгал нуурын отоглох цэгт ариун цэврийн байгууламж барих (7 суултуур, 3 шээлтүүртэй байгууламж 1 ширхэг)” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Эрдэнэт есөн зуун ерэн ес групп” ХХК-тай 60,000,000 (жаран сая) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчны газрын дарга (А.Гантөмөр)-д олгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Эрдэнэт есөн зуун ерэн ес групп” ХХК-ийн захирал (Э.Оюунбат)-д даалгасугай.

3. Ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Булган аймгийн Тэшиг сумын Засаг даргын тамгын газар (Б.Батсайхан), хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Булган аймгийн Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА


Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010491

Сүдэг Ажил 2026 өдөр Doc/2026/Захирамж

Аймгийн Засаг даргын 2026 оны  
05 дугаар сарын 19-ны/ний өдрийн  
А/367 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт




Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хойш хуанлийн 30 хоног	А.Гантөмөр
2	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Очирсүрэн
3	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Очирсүрэн А.Гантөмөр

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны  
05 дугаар сарын 19 ны/ний өдрийн  
А/367 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн  
ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Барилгын инженер	С.Батбямба	А.Гантөмөр
2	ХАБЭА-н ажилтан	Д.Гантуул	
3	Гагнуурчин	Э.Оюунбат	
Машин механизмын жагсаалт			А.Гантөмөр
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар	
1	Ачааны автомашин	9735 ОРО	

--о00о--